

2022 оны 3-р сарын 2

Эрхэм хүндэт хамт олон танаа (Захирал, багш, ажилчид),

Эрх тэгш байдал гэдэг нь үйл ажиллагааг төлөөлөх үг юм.

Хорь гаруй жилийн өмнө намайг сурагч байхад тэр үеийн нэлээд хэдэн сургууль үйл ажиллагаандаа суралцагчдын соёл, ёс заншлын онцлогийг харгалзан үзэх арга барилыг төлөвлөлтийнхөө тэргүүлэх чиглэл болгож байсан юм. Жим Кроугийн хууль тогтоомж хүчингүй болсноор танхимын сургалт, сургуулийн сахилга батыг олон үндэстний үзэл баримтлалын үүднээс хардаг уламжлал руу шилжсэн юм. Үүнээс хойш сургуулиад илүү олон ургальч болсон билээ. Виржиниа мужийн сургуулиуд нийгэм эдийн засгийн статусын хувьд олон ургальч болоод зогсохгүй 2000 оны [АНУ-ын тооллогод](#) Арлингтоны Төрийн Өмчит Сургуулиад арьс өнгө, үндэс угсаа, олон хэлтэй суралцагчдын хувьд асар их өөрчлөлт гарсан нь харагдсан юм.

Багш нарт хичээлээ төлөвлөхдөө суралцагчдын олон талт байдал, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хэрэгцээ зэргийг харгалзан үзэх, суралцах үйл явц дахь иргэдийн оролцоог бэхжүүлэх, англи хэлээр хоёр дахь хэлний түвшинд ярьдаг суралцагчдын онцлогийг тусгах, сураглцагсдын соёлын онцлог зэргийг хичээлээ төлөвлөхдөө харгалзан үздэг болгохын тулд энэхүү чиглэлээр мэргэжлээ дээшлүүлэхэд хөрөнгө оруулах нь зүйтэй хэмээн боловсролын салбарын удирдах ажилтнууд үзэж байна. Суралцагсдын бие бүрэлдхүүн эрс өөрчлөгдчихөөд байхад багшлах боловсон хүчний дийлэнх гетеросексуаль бэлгийн чиг хандлагатай, Христийн шашин шүтдэг бөгөөд цагаан арьстай байгаа юм.

Хэдийгээр олон соёлыг багтаасан нэгэн үеийн боловсролын тогтолцооны дагавар болон гарч ирсэн хэмээх үздэг ч олон талт байдал, тэгш байдал болон тэгш хамралт (DEI) зэрэг үзэл баримтлал нь тухайн сургууль БҮХ суралцагчийн хэрэгцээг хангаж чадаж буйг баталгаажуулах суурь үзүүлэлт болсон байна. Энэхүү суурь үзүүлэлтийг нэвтрүүлсний зорилго нь улам бүр нэмэгдэж, улам олон олон ургальч болж буй суралцагчдыг сургах чиг баримжааг сургуулиудад олгох явдал байлаа. Гэвч цаг хугацааны явцад тэгш байдлыг олж авахын тул хүн нэг юмаа алдах ёстой хэмээн энэхүү суурь үзүүлэлтийг буруугаар ойлгох болсон байна.

Түүнчлэн энэхүү үндэслэл нь маргаан дагуулсаар ирсэн бөгөөд тэгш байдал нь зөвхөн арьсны өнгөнд тулгуурладаг болохоос бүх суралцагчид хамаарахгүй хэмээсэн үндэслэлээр анхан шатны сонгуульд нэр дэвшигсэд маргаан үүсгэж сонгогчдын дэмжлэг авахын төлөө өрсөлддөг. Хэт олон кампанит ажлын сурталчилгаа, хуулийн төсөл нь суралцагчдыг мөлжлөгт оруулж, сурган хүмүүжүүлэгчдийг маань улс төрийн ашиг сонирхлын золиос болгож байна.

Үүнээс гадна тэгш байдлын зорилгыг биелүүлэхэд саад болж буй бусад зүйл бол нөөцийг шударга, тэнцвэртэй, тэгш байдлаар бүх суралцагчид хуваарилах санхүүжилт дутмаг байдаг явдал юм. Жишээлбэл, Арлингтоны Төрийн Өмчийн Сургуулиудын суралцагч бүрт ашигтай байдлаар сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох нэг арга зам нь сургалтын хөтөлбөрт аудит хийлгэх явдал юм. Хэрвээ бид бүх суралцагчийг хэрхэн сурч байгаагаа тайлбарлаж, суралцах үйл явцад идэвхтэй оролцож, сурч мэдсэнээ бүтээлч байдлаар илэрхийлэх чадвартай болгохыг хүсч байвал суралцах үйл явцыг хамтын аргаар шалгах хэрэгтэй.

Суралцагчид болон ажилтнуудаа чадавхжуулах алхам хийх бүртээ олон талт байдал, тэгш байдал болон тэгш хамралт зэрэгт манай албанаас дараах тодорхойлолтыг барьдаг болно:

Олон талт байдал: Арлингтоны Төрийн Өмчит Сургуулиуд дахь хүмүүсийн ялгамж чанар харилцан адилгүй байдаг. Арлингтоны сургуулиудад бид статус, бэлгийн чиг хандлага, гарал үүсэл, шашин шүтлэг, арьс өнгө, гэр бүлийн байдал, цэргийн алба хаасан эсэх, хүйсийн ялгаа, жирэмсэн эсэх, генетикийн мэдээлэл, иргэний харьяалал, хөгжлийн бэрхшээл, нийгэм, эдийн засгийн байдал, нас, бие бялдар болон хүмүүсийн ялгааг мэдэрч, илэрхийлж болох бусад чиглэлээр хүн бүр өвөрмөц байдгийг хүлээн зөвшөөрдөг. Бид мөн үзэл санаа, үзэл бодол болон үнэт зүйлийг олон талт байдлын бас нэгэн чухал хэмжүүр хэмээн үздэг. Олон талт байдал гэдэг нь хувь хүн эсхүл бүлэг бүрт өөрийн гэсэн ойлголт, үзэл бодол байдаг бөгөөд тэдгээр бодгал нь нийгмийн норм нормативаас хамааралгүйгээр нийгмийн харилцаанд оролцохыг хэлдэг.

Боловсрол дахь тэгш байдал: Суралцагчид болон сургуулийн барилга байгууламжийн хэрэгцээнд тулгуурлан нөөцийг шударга, эрх тэгш хуваарилахад хүргэдэг бодлого, үйл ажиллагаа, журмыг тодорхойлох, хэрэгжүүлэхийг эрх тэгш байдал хэмээн бид үздэг. Бүх суралцагч, тэдний гэр бүл, ажилтан, ажилчдыг амжилтай байлгах нөөцийг баталгаажуулахын тулд Арлингтоны Төрийн Өмчит сургуулиуд нь тэгш байдлын дөрвөн хандлагыг хэрэгжүүлдэг. Үүнд засаглалын тэгш байдал, боловсролын тэгш байдал, ажиллах хүчний тэгш байдал, үйл ажиллагааны тэгш байдлын зарчим зэрэг ордог.

Тэгш хамрагдалт: Арлингтоны Төрийн Өмчит Сургуулиудын олон талт үйл ажиллагаанд идэвхтэй, санаачлагатай, байнгын оролцохыг тэгш хамрагдалт хэмээн үзнэ. Арлингтоны Төрийн Өмчит Сургуулиуд дахь тэгш хамралт нь бодлогын шийдвэр, сургуулийн болон сургалтын үйл ажиллагаа, гэр бүл/олон нийтийн үйл ажиллагаа болон хичээлээс гадуурх үйл ажиллагаа явуулахад сурагчдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч хөтөлбөр зэрэгт тусгах явдал юм.

Тэгш байдлыг буруугаар тайлбарлах нь АТӨС-иудын системийн суралцагсад болон гэр бүлийнхэн хөгжин дэвжихэд нь туслах учиртай DEI буюу олон талт байдлын, тэгш байдлын болон тэгш хамралт бүхий үйлчилгээнүүд хүссэн үр дүнд хүрэхгүй байх вий хэмээн миний бие болгоомжилж байна. Үүний үр дүнд, бүх суралцагчийн ашиг тусын тулд үйлчлэх ёстой тэгш байдлын олон санаачлагаа сургуулиудын удирдлага болон багш нар цуцлаад байгаа билээ. Төрийн өмчит сургуулиудыг нөөцийг хуваарилах, иргэд хоорондын түншлэл, суралцагчдын соёлыг

харгалзан үздэг үйл ажиллагаатай болгох гэсэн багш сурган хүмүүжүүлэгч, консервативчууд, либеральчууд болон эдгээрийн дундах үзэлтнүүдийн хэдэн арван жилийн хөдөлмөр энэхүү болгоомжлолоос шалтгаалан саарахад хүрээд байна.

Тэгш байдал бол хүн бүрийн асуудал! Тэгш байдал нь олонхтой адил цөөнхөд ч үйлчлэхээр оршин байдаг. Жишээлбэл, манайд зөвхөн тээврийн хэрэгслийн хүрэлцээгүйгээс болж хичээлээс гадуур давтлага авах, хичээлээс гадуурх арга хэмжээнд хамрагдах боломжоор сурагчид дутагддаг. Эдгээр асуудлыг тэгш байдлын өнцгөөс шийдвэрлэх нь ийм хэрэгцээт гэр бүлийн асуудлыг шийдэх боломж бидэнд олгох юм.

Боловсролын салбарын хөтөлбөр дэх маргаантай концепциудтай тэгш байдлыг холбож үзэх нь түүнийг гоц шаардлагагүй маргааны цэг болгосон юм. Хагарал хуваагдлын аюул заналхийлээгүй салбаруудад ч гэсэн тэд хүртээмжит байдлын цоорхойг хэрхэн олж илрүүлэх талаар олон удаа бодож, бүх сурагчид тэгш боловсрол олгохын тулд өгөгдөлд суурилсан аргыг ашиглахаа түр зогсоод байна. Арлингтоны Төрийн Өмчит Сургуулиудад боловсролын тэгш байдлын зарчмыг хэвээр байлгахын төлөө бид ажиллах болно.

Тэгш байдлын гол тулгуур бол мэдээллийн дүн шинжилгээ юм. Өгөгдөлд суурилсан ажиллагаа нь Арлингтоны Төрийн Өмчит Сургуулиудын субьектив шийдвэр гаргахаас зайлсхийхэд туслах зорилготой юм. Үнэнч шударга, сэтгэл хөдлөлд автаагүй алхмууд хийхэд хөтөлдөг шинжлэх ухаанч, объектив дүн шинжилгээ хийхээ бид болихгүй гэдэгт итгэлтэй байна. Боловсролын тэгш байдал гэх мэт ойлголтууд нь хагалан бутаргах хүч болж байна гэсэн зовнилыг арилгахын тулд бид ажиллах болно. Үүний тулд олон талт байдал, эрх тэгш байдал, тэгш хамралттай холбоо бүхий шийдвэр гаргах үед АТӨС-иуд үргэлж олон ургальч үзэл бодлыг хүндэтгэж байхыг миний бие Олон талт байдал, эрх тэгш байдал, тэгш хамралтын асуудал эрхэлсэн ажилтны хувьд амлаж байна.

Хүндэтгэсэн,



Олон талт байдал, Тэгш байдал, Тэгш хамралт хариуцсан ахлах ажилтан

Жэйсон Оттли, Ph.D.